



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/С86

Зуунмод

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2014 оны А/67 дугаар захирамжийн нэг дэх заалтад “Зуунмод сумын 5 дугаар багийн нутаг “1000 айлын орон сууц төсөл”-ийн батлагдсан төлөвлөлтийн дагуу 1,0 га газрын 640 сурагчтай сургуулийн зориулалтаар аймгийн Боловсролын газарт” гэснийг Ланд Менежер мэдээллийн сан нэвтэрсний дагуу “Зуунмод сумын Номт 1-р баг, Манзушир өргөө хотхон, Наадамчдын гудамж 302 тоотод Ерөнхий боловсролын сургуулийн зориулалтаар 1 га /10000 м²/ газрыг Боловсрол, соёл, урлагийн газар /9061029/-т гэж өөрчилсүгэй.

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ